



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 158

Чойбалсан

Г

Дэмжлэг үзүүлэх тухай

Т

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.7, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5, “Дорнод аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.2.9, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 9 сарын 29-ны өдрийн 18-1/01 тогтоолоор батлагдсан аймгийн 2023 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөөний 1.3 дахь заалт, “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 19/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулах, олон улс, улс, бүс, аймгийн чанартай уралдаан, тэмцээнд тамирчдыг бэлтгэн оролцуулахад зориулж 85,000,000 (наян таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлж, төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

2. Дэмжлэгт шаардагдах 85,000,000 (наян таван сая) төгрөгийг аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын 2.52 дахь “Биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулах, олон улсын болон улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх” зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (П.Бат-Өлзий)-д зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Биеийн тамир, спортын газартай байгуулах орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх гэрээг боловсруулан батлуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж дэмжлэгт хамрагдсан тамирчдын бүртгэл мэдээллийн сан үүсгэн хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Э.Эрдэнэбилэг), Санхүү, төрийн сангийн хэлтэс (В.Цэнгэлмаа)-т даалгасугай.

4. Тамирчдад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ, тэмцээн уралдааныг чанартай зохион байгуулж, хэрэгжилт үр дүнг тогтмол олон нийтэд танилцуулж ажиллахыг Биеийн тамир, спортын газрын дарга (Б.Чимэддорж)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн засаг даргын орлогч (Ш.Ёл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН



212401106

Аймгийн Засаг даргын ~~11/12~~ оны
01.. дугаар сарын 08 –ны өдрийн
~~11/12~~ дугаар захирамжийн хавсралт

БИЕЙИН ТАМИР, СПОРТЫН УРАЛДААН, ТЭМЦЭЭН
ЗОХИОН БАЙГУУЛАХ, ОЛОН УЛС, УЛС, БУС, АЙМГИЙН
ЧАНАРТАЙ УРАЛДААН ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХОД
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАРДАЛ

д/д	Спортын төрөл	Үйл ажиллагаа	Төсөв өртөг (төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн
1		Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдэд зориулсан үндэсний бөхийн барилдаан	10,000,000	Арга хэмжээний тоо	2
				Оролцох тамирчдын тоо	128
2	Шагайн харваа	Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах зардал, Тамирчдын олон улс, улс болон бүсийн чанартай тэмцээнд оролцоход байр, хоол, замын зардлын дэмжлэг үзүүлэх	2,000,000	Арга хэмжээний тоо	5
				Оролцох тамирчдын тоо (эр-60)	
3	Мөсөн шагай	Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах зардал, Тамирчдын олон улс, улс болон бүсийн чанартай тэмцээнд оролцоход байр, хоол, замын зардлын дэмжлэг үзүүлэх	3,000,000	Арга хэмжээний тоо	5
				Оролцох тамирчдын тоо (Эр30)	
4		Зүүн бүсийн сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулах	5,000,000	Арга хэмжээний тоо	1
				Оролцох тамирчдын тоо	100
5	Пара спорт	Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах, Тамирчдын олон улс, улс болон бүсийн чанартай тэмцээнд оролцоход байр, хоол, замын зардлын дэмжлэг үзүүлэх	2,500,000	Арга хэмжээний тоо	1
				Дэмжлэг авах тамирчдын тоо (эр-7, эм-5)	12

6	Шатар	Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах зардал, Тамирчдын олон улс, улс болон бүсийн чанартай тэмцээнд оролцоход байр, хоол, замын зардлын дэмжлэг үзүүлэх	3,000,000	Арга хэмжээний тоо	1
				Дэмжлэг авах тамирчдын тоо	20 (эр-12, эм-8)
7	Хөнгөн атлетик	Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах зардал, Тамирчдын олон улс, улс болон бүсийн чанартай тэмцээнд оролцоход байр, хоол, замын зардлын дэмжлэг үзүүлэх	12,000,000	Арга хэмжээний тоо	2
				Дэмжлэг авах тамирчдын тоо	250 (эр-120, эм-130)
8	Бадминтон	Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах зардал, Тамирчдын олон улс, улс болон бүсийн чанартай тэмцээнд оролцоход байр, хоол, замын зардлын дэмжлэг үзүүлэх	3,500,000	Арга хэмжээний тоо	1
				Дэмжлэг авах тамирчдын тоо	80 12 (эр-40, эм-40)
9	Пауэрлифтинг	Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах зардал, Тамирчдын олон улс, улс болон бүсийн чанартай тэмцээнд оролцоход байр, хоол, замын зардлын дэмжлэг үзүүлэх	5,000,000	Арга хэмжээний тоо	1
				Дэмжлэг авах тамирчдын тоо	10 (эр-5, эм-5)
10	Бодибилдинг	Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах зардал, Тамирчдын олон улс, улс болон бүсийн чанартай тэмцээнд оролцоход байр, хоол, замын зардлын дэмжлэг үзүүлэх	3,500,000	Арга хэмжээний тоо	1
				Дэмжлэг авах тамирчдын тоо	10 (эр-5, эм-5)
11	Ширээний теннис	Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах зардал, Тамирчдын олон улс, улс болон бүсийн чанартай тэмцээнд оролцоход байр, хоол, замын зардлын дэмжлэг үзүүлэх	2,000,000	Арга хэмжээний тоо	5
				Дэмжлэг авах тамирчдын тоо	250 (эр-125, эм-125)
12	Таеквондо	Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах зардал, Тамирчдын олон улс, улс болон бүсийн чанартай тэмцээнд оролцоход байр, хоол, замын зардлын дэмжлэг үзүүлэх	2,000,000	Арга хэмжээний тоо	2
				Дэмжлэг авах тамирчдын тоо	100 (эр-30, эм-70)

13	Чөлөөт бөх	Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах зардал, Тамирчдын олон улс, улс болон бүсийн чанартай тэмцээнд оролцоход байр, хоол, замын зардлын дэмжлэг үзүүлэх	3,000,000	Арга хэмжээний тоо	4	
				Дэмжлэг авах тамирчдын тоо	300 (эр-150, эм-150)	
14	Самбо бөх	Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах зардал, Тамирчдын олон улс, улс болон бүсийн чанартай тэмцээнд оролцоход байр, хоол, замын зардлын дэмжлэг үзүүлэх	2,500,000	Арга хэмжээний тоо	6	
				Дэмжлэг авах тамирчдын тоо	400 (эр-250, эм-150)	
15	Жүдо бөх	Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах зардал, Тамирчдын олон улс, улс болон бүсийн чанартай тэмцээнд оролцоход байр, хоол, замын зардлын дэмжлэг үзүүлэх	3,000,000	Арга хэмжээний тоо	7	
				Дэмжлэг авах тамирчдын тоо	(эр-350, эм-350)	
16	Бокс	Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах зардал, Тамирчдын олон улс, улс болон бүсийн чанартай тэмцээнд оролцоход байр, хоол, замын зардлын дэмжлэг үзүүлэх	5,000,000	Арга хэмжээний тоо	6	
				Дэмжлэг авах тамирчдын тоо	78 (эр-40, эм-38)	
17	Тамирчдын олон улс, улс болон бүсийн чанартай тэмцээнд оролцоход байр, хоол, замын зардлын дэмжлэг үзүүлэх		10,000,000	Дэмжлэг авах тамирчдын тоо	60	
18	Иргэдийн дунд нийтийн биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулах зардал		8,000,000	Зохион байгуулах арга хэмжээний тоо	16	
НИЙТ ДҮН			85,000,000			